



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 1/04

Амардалай

Хагас жилийн Малын түүвэр судалгааны  
комисс томилох тухай

Статистикийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3 дахь заалт, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйл, Хөдөө аж ахуйн тооллогын тов тогтоох тухай, Засгийн газрын 2012 оны 137 дугаар тоотыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд 2023 оны Хагас жилийн малын түүвэр судалгааны ажлыг эрхлэн явуулах сумын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: М.Баярсүх (Сумын Засаг дарга)

Гишүүд: Б.Баатарсүрэн (3-р багийн Засаг дарга)

Г.Сосорбурам (2-р багийн Засаг дарга)

Б.Довуучий (1-р багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: Ч.Баярмаа (Санхүү, төрийн сангийн албаны дарга)

2.Хагас жилийн малын түүвэр судалгааны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай. 2023 оны 05 дугаар сарын 30-аас 06 дугаар сарын 09-ны өдөр хүртэл хугацаанд сумын хэмжээнд малын түүвэр судалгааг нүдээр үзэж нэг бүрчлэн тоолох ажлыг Үндэсний статистикийн хорооноос баталсан заавар удирдамжийн дагуу зохион байгуулахыг тооллогын комиссын нарийн бичгийн дарга (Ч.Баярмаа)-д үүрэг болгосугай.

3.Малын түүвэр судалгаанд явах бүрэлдэхүүнийг баг тус бүрээр 1-р хавсралтаар, хяналтын ажлын хэсгийг 2-р хавсралтаар тус тус баталсугай.

4.Малын түүвэр судалгааны арга хэмжээний зардал 545,027 (таван зуун дөчин таван мянга хорин долоон) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн данснаас зардлыг гарган зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (С.Нарантунгалаг), нягтлан бодогч (Г.Дэжидсүрэн) нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА

М.БАЯРСҮХ

Сумын Засаг даргын 2023 оны А/64 тоот  
захирамжийн 1 дүгээр хавсралт

ТООЛЛОГЧ НАРЫН БҮРЭЛДЭХҮҮН

- 1-дүгээр тоологч Б.Довуучий /Баянбулаг багийн Засаг дарга/  
2-дугаар тоологч Г.Сосорбурам /Цахиурт багийн Засаг дарга/  
3-дугаар тоологч Б.Баатарсүрэн /Дэлгэр-Эмт багийн Засаг дарга/

ХЯНАЛТЫН ТООЛЛОГЫН АЖЛЫН ХЭСЭГ

Хэсгийн ахлагч Ч.Баярмаа /Санхүү албаны дарга/